


ТҮҮХИЙН СУДАЛГААН ДАХЬ САРЬДАГИЙН ХИЙД: ЭРЭЛ ХАЙГУУЛ, СААД БЭРХШЭЭЛ


С.Чулуун

Сарьдагийн хийдийн эрэлд

Монгол улсад Үндэсний ардчилсан хувьсгал ялсны дараа шинжлэх ухааны байгууллагын үүсэл болох Судар бичгийн хүрээлэн 1921 оны 10 дугаар сард Богд хааны зарлигаар байгуулагдсан юм. Шинэ Монгол улсад байгуулагдсан Судар бичгийн хүрээлэн нь юуны өмнө монголчуудын түүх, хэлний асуудлыг судлах, эрж хайх, холбогдох эх баримтыг цуглуулах ажлыг эхлүүлэв. Тухайн үед Судар бичгийн хүрээлэнд ахмад бичгийн түшмэдээс гадна Зөвлөлтийн зарим судлаачид ажиллаж байжээ. Тэдний дунд Всеволод Игнатьевич Лисовский, Барон Витте нарын нэр тэмдэглэгдсэн байдаг. Тэд 1913 оны Монгол улсын Ерөнхий сайд, Сайн ноён хан Намнансүрэнгийн айлчлалын мөрөөр байгуулагдсан Монгол Улсын Хөрөнгийг захирах газарт, 1915-1916 оны хооронд манай хүн ам, эд хөрөнгийн тооллого явуулах үед ажиллаж байв. В.И.Лисовский 1915 онд Монгол улсад анх удаагаа ирж, П.В.Виттегийн туслахаар ажиллаж байсан бөгөөд хөрс сайжруулагч-инженерийн мэргэжилтэй, Монголын газар зүйг сонирхон судлагч байв. Тэрээр 1924 онд анхны газрын зургийг зохиосон бөгөөд анхны номын сан, музей болон тус хүрээлэнгийн газар зүйн тасгийг байгуулахад онцгой гавьяа байгуулжээ. 1927 онд нутаг буцсан мэдээ бий.



Зураг №1. 1922 онд Судар бичгийн хүрээлэнгээс Сарьдагийн хийдэд В.И.Лисовский нарыг илгээж ажиллуулахаар Засгийн газраас зөвшөөрөл хүссэн бичиг. МУУТА. Ф-23.



1921 онд Судар бичгийн хүрээлэнгээс нэн тэргүүнээ Монгол нутагт байгаа хуучны эд өлгийн зүйлсийг эрж хайх, судлах ажлыг эхлүүлэхээр шийдэж, 12 дугаар сарын 4-нд хуралдсан хурлын дөрөвдүгээр тогтоолын 2-р зүйлд:

“Монгол улсын бүх газрын зургийг орос түшмэл Лисовский, Барон Витте нараар эрхлүүлэн зурж үйлдүүлэхээр тогтоосноос гадна бүх газрын хязгаарын зураг хэмжээ цэс дэвтрийг манай хүрээлэнгийн газраас олж өгөхөөр хэлэлцэв”¹


хэмээн тэмдэглэсэн байдаг. Төд удалгүй 1922 оны 5 дугаар сарын 25-нд урин цаг болоход Судар бичгийн хүрээлэнгийн 6-р хурлаар:

“Хоёрдугаар зүйл. Харьяат хүрээлэнгийн гишүүн бөгөөд хавсарсан нарийн бичгийн дарга Бат-Очир зураг үйлдэх эрдэмт орос Лисовский, бага орчуулагч буриад Дорж нарыг хөлсний морь тэрэг хөлслүүлэн илгээж, Сарьдагийн эвдэрхий хийдийн зэрэг газар явж зураг хэмжээ зэргийг бүдүүвчлэн авхуулах ба янз байдлыг байцаан үзүүлэх жич бас элдэв ургамал бодисын зэрэг зүйлийг шинжээр гаргах явдлыг хэлэлцэн тогтов”²

гэсэн байна. Энэ удаад Оросын харьяат В.И.Лисовскийг ажиллуулах болсон нь санамсаргүй хэрэг биш байв. В.И.Лисовский нь өмнө 1915 оны Монгол улсад явуулсан хүн ам-статистикийн тооллогод явахдаа Хэнтий ууланд явж тус газарт хүрсэн бололтой. Тэрээр Сарьдагийн хийдэд хүрч, бага зэрэг малтлага хийн нэлээд тооны шавар бурхан шашны эд өлгийн зүйлс олж авч явсан байна. Тэд Оросд байсан Л.В.Котвичд энэ тухайгаа мэдээлсэн гэж үздэг.

Зураг №2. Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Бат-Очир, Оросын судлаач В.И.Лисовский нарыг Сарьдагийн хийдэд томилох хурлын тэмдэглэл. МУУТА. Ф-23. Д.1. ХН-6.

1 МУУТА. ф.23, д.1, хн.3, Монгол бичгээр, гар бичмэл, эх
2 МУУТА. Ф.23. д.1. хн.6.



Зураг №3. Оросын Газар зүйн Нийгэмлэгийн архивт хадгалагдаж буй В.И.Лисовскийн Сарьдагт ажилласан тайлангийн хэсгээс. 1924.

Эдүгээ ОХУ-ын Эрмитаж Улсын музейд 1916 онд шилжсэн Бяшковын цуглуулга хэмээх бүртгэлтэй дурсгалууд байгааг тус музейн Монголын сан хөмрөгийг хариуцагч Ю.И.Елихина тусгайлан судалж энэхүү каталогид оруулсан болно. Ямартаа ч Сарьдагийн хийдийн хамгийн анхны мэдээлэл В.И.Лисовскийтой холбоотой байдаг.

Судар бичгийн хүрээлэнгээс энэ удаагийн хээрийн шинжилгээний ангид бие хамгаалах цэрэг нэг, уналга ачлагын морь тав, морь мал хадгалах хүн нэг, бие хамгаалах буу хоёр, морь тэрэг нэг, барих майхан нэгийг тус тус гаргаж өгч зам явах бичиг гаргуулахаар Засгийн газарт мэдэгдэж байжээ. Өөрөөр хэлбэл, энэ нь Судар бичгийн хүрээлэнгийн хувьд археологийн дурсгал бүхий газарт ерөнхий хайгуул шинжилгээ явуулах хамгийн анхны шийдвэр болно. Тус хээрийн шинжилгээний ангийг Бат-Очир хэмээх хүн тэргүүлэн явсан бөгөөд Түшээт хаан аймгийн Дархан Чин вангийн хошууны нутаг мөн болохыг тодорхой заажээ. Харин В.И.Лисовскийн Сарьдагт ажилласан тайланг өнөө хэр Улсын Архиваас олж үзсэнгүй.

Харин Сарьдагийн хийдийн талаар албан ёсоор судлан шинжлэх ажлыг 1922 оны зун Судар бичгийн хүрээлэнгээс явуулсны дараа МонГа-гийн Бюллетень сэтгүүлд мөн оны 8 дугаар сарын 12-ны №19-д В.И.Лисовскийн тухай нийтлэл мэдээ гарчээ.

“Ноён Лисовскийн удирдсан эрдэм шинжилгээний анги Өндөр гэгээн Занабазарын тодорсон үед холбогдох эртний сүмийн балгасыг олж илрүүлэн, түүхийн нэн сонирхолтой нээлт хийлээ. Сүм хийд нь 7 аймагт хуваагдан харьяалагдаж байсан бөгөөд үнэхээр ч хавцал амны хамгийн эхэнд, уулын энгэрт модны хөвөөнд хуучны түвэд хийцийн 7 барилга байх ажээ. Түүний нэгд нь одон орон, нөгөөд нь анагаах ухаан, гурав дахид нь гүн ухааны хэсэг гэх зэргээр байрлаж байсан бололтой. Шаваас, хананы хэсэг нь хадгалагдсан ч бүх модон хэсэг нь өмхөрч хэмхрэн салж ойчсон, мод бут ургасан байна. Галдан хутагт Халхыг дайлах үеэр Өндөр гэгээн Занабазар Бээжин рүү зугтан оджээ. Өргөөний Судар бичгийн хүрээлэн малтлагыг үргэлжлүүлэх бодолтой байгаа аж. Түүнчлэн ноён Лисовский гүн тайгад буй сүмийн туурь хүрэх замдаа цаст оргил болон нуурын дэргэдээс Монголын хувьд өнөөг хүртэл хаана ч тэмдэглэгдээгүй зарим нэгэн ургамал олжээ.”

14

ить еще 8 крейсеров, 24 истребителя и 22 подводных лодки.

Не изготовление нового оружия для пехотных частей потребовалось 23 миллиона пец. Все это — на случай войны с Америкой.

Что приносят Японцы.

Они приносят не культуру, не развитие промышленности, а вот что: на Амуре русское население разоряется от бесконечных контрибуций японских войск. В Николаевке японцы устраивают публичные побои, инсценируют неприкрытый разгром и пытки.

В борьбе с русским влиянием японцы используют русские же люди — интеллигенцию. Русским рабочим и крестьянам они запрещают принимать свыше 20 процентов русских рабочих.

И только изменники России — разведчики Семеновы, Меркуловы и прочие безобразнейшие могут отстаивать японскую интервенцию.

Друзья-приятели.

По словам Русского Голоса, ряд белоэмигрантских генералов (Семашевский, Петухов, Завьялов, есаул Буклаковский и др.) поступили на службу к Уэан-Цзо-Дину, в качестве инструкторов артиллерийского дела.

По Монголии.

Через три дня вышлывает о таможенной реформе.

Подчеркивая необходимость привлечения в Правительственную комиссию людей, страдающих от недоброты таможен, т. е. торговцев, чиновников, р.ш. останавливается на следующих пунктах.

1) Самым большим злом является добавочная пошлина, которая не только нарушает коммерсанта, но в корне убивает свободную торговлю.

2) Не меньшим злом является то, что таможенные расценки пехотные из твердого префиксанта цен, а каждамы разрасценивают товар произвольно, как им заблагорассудится.

3) Оплата пошлины по розничной цене дает ущерб крупному предпринимательству, и держит в скважных рубашках любого торговца.

говца, который хотел бы убыток на одном сорте однородных товаров покрыть прибылью от товаров другого сорта.

4) Совершенно несостоятельны внутренние пошлины в пределах отдельного мест той же Монголии. Работа таможен от этого сильно затрудняется, а доход от внутренних пошлин грошевые. — Их с большим успехом можно было наверстать на ввозной и вывозной пошлине.

5) Необходимо обратить внимание на грабобы, провозов, прилирки и высокомерие со стороны отдельных чиновников таможни. Нельзя держать дорожниц палками, маслами, с лошадыми и товаром часто из за пушковой бумаги. Чиновникам должно внушить, что не публика для них, а они для публики.

В части касающейся пошлин, автор этих строк рекомендует выработать более или менее постоянный тариф, хотя бы в три месяца, причем расценка должна быть оптовая, а не розничная.

Еженедельные сведения о колебании оптовых цен можно собирать через организации местных торговцев и кооперативы и проверять их посредством собственного аппарата таможни.

Таим образом будет установлена средняя оптовая цена на наиболее ходовые товары.

Работу чиновников надо строго распределить и специализировать. Каждый должен заниматься точно определенным делом и отвечать за свои поступки.

Редакция полагает, что соображения г. Ш. представляют практический интерес и должны быть приняты во внимание.

К вывозу и обработке шерсти.

Шерсть является одним из важнейших продуктов сельского хозяйства в Монголии. По имеющимся данным Монголии выбрасывает ежегодно на рынок более полумиллиона пудов бараньей шерсти и до 40.000 верблюжьей. Это за вычетом тех 200.000 пудов бараньей шерсти и 10.000 верблюжьей, которые бесценово и расточительно расстраиваются населением на текущие потребности.

При мало-мальски усовершен-

ствованных способах сбора, количество это увеличилось бы самое меньшее в полтора раза.

К сожалению, продажная стоимость монгольской шерсти крайне обесценивается отсутствием хоть сколько нибудь благоустроенных шерстомоек. Оборудование шерстомоек — это настолько непростое и возмущающее дело, что медлить с ним — значит терять миллионы рублей дохода.

Создание суконных фабрик, овчинно-шубных заводов и мастерских, хотя бы самого простейшего устройства, тоже является неотложной необходимостью.

Экспедиция на верховья р. Толы.

Организованная под руководством г. Лисовского научная экспедиция привела к интересному историческому открытию: найдены развалины старинного монастыря, относящегося ко временам первого перерождения Ундур-Гегена (около 1650 г.).

Когда то монастырь был разделен на 7 аймаков и действительно в самой вершине одной из пещер, под гальцем, на краю леса и расположено 7 зданий старинного тибетского стиля, в одном здании помещалось отделение астрономии, в другом — медицина, в третьем — отделение философии и т. д. Часть стен сохранилась, виден гранит с прокладкой слюда на глине, сохранилась и штукатурка, зато все деревянные части истлели, провалились, обломки заросли бурьяном, кедрами.

В то время или завоевания Халхи перерожденцем Галданом Бошкю, и Ундур-Геген, испугавшись, бежал в Пекин.

Ургинский Ученый Комитет современем предполагает продолжить раскопки.

Между прочим по пути к развалинам монастыря, расположенного в глухой тайге, возле озерных снежных вершин, г. Лисовский нашел несколько растений, до сих пор нигде не отмеченных в отношении Монголии.


Издатель: Политуправление

Редактор: В. Т. Дадманя.

Тираж 200 экз.

Русско-Монгольская Типографическая Фабрика

Зураг №4. Сарьдагийн хийдэд ажилласан В.И.Лисовский нарын МонТа-гийн Бюллетень сонинд "Туул голын эхэн дэх хээрийн шинжилгээний анги" нэртэй хэвлүүлсэн мэдээ. Бюллетень. №19. стр.14. МУУТА-т буй.



Зураг №5. 1924 оны Улсын анхдугаар Их хуралд Судар бичгийн хүрээлэнгийн дарга О.Жамъяны хэлэлцүүлсэн илтгэлийн хэсэг. МУУТА. Ф-23. Д. 1. ХН 36.

Энэхүү мэдээллийг Сарьдагийн хийдийн тухай гарсан хамгийн анхны албан ёсны мэдээлэл гэж үзэж байна.

1924 оны 10 дугаар сард хуралдсан Улсын анхдугаар Их хуралд Судар бичгийн хүрээлэнгээс хэлэлцүүлсэн илтгэлийн тавдугаарт:

“Монголын эх түүхэнд холбогдох зүйлүүдийг сурвалжилж Сарьдаг хийд Хэсэг байшин зэргийг хэдэн удаа сурвалжлагчид шинжилэгчидийг явуулан зураг хөргийг үйлдэж хойно хэрэглэхэд бэлтгэжээ. Энэ тухайд ховор ховор бичиг зүйлүүдийг олхыг хичээсээр ирсэн ба сургуульд хэрэглэх Монголын түүхийн зураг үйлдсээр буй”³ хэмээн дурджээ.

3 МУУТА. ф.23, д.1, хн.36, дээрээ “нууц” гэсэн тамгатай


Мөн онд В.И.Лисовскийн “Туул голын эхэн дэх хуучны эвдэрхий балгасанд зорчсон нь” хэмээх нэртэй бүтээл бичигдсэн бололтой. Судар бичгийн хүрээлэнгийн ажилтан В.И.Лисовскийн П.К.Козловт өгсөн “Туулын дээд эхний хуучны хийдэд хайгуулаар зорчсон нь” хэмээх гар бичмэл тайлан ОХУ-ын Газар зүйн Нийгэмлэгийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байна. Түүнийг В.И.Лисовскийгоос П.К.Козловт дамжуулж өгсөн гар бичмэл юм. Тус гар бичмэлд Туулын дээд эхэнд явсан тухай 16 нүүр тайлан бөгөөд Сарьдаг хийдийн орчин болон хийдийн хэрмийн зургийг сэргээж, барилгын ерөнхий план зургийг зурсан байна⁴. Тус машиндмал эхийг бид орос Монгол хэлээр хэвлэн нийтлүүлэх болно. Уг гар бичмэл П.К.Козловыг Монгол улсад 1923-1926 онд Монгол-Түвэдийн шинжилгээний ангийн хүрээнд ажиллах үед түүнд хүрсэн болов уу гэж төсөөлнө.

Харин В.И.Лисовский Зөвлөлт улсдаа буцах үедээ буюу 1927 онд “Землеведение” сэтгүүлд Сарьдагийн хийдэд зорчсон асуудлаараа өгүүлэл нийтлүүлжээ.

4 Рукопись В.И.Лисовского Поездку к развалинам старого монастыря в верховья Толы. Отчет / на правах рукописи. 1924/2/1.



Зураг №6. Улаанбаатар. Экспедицийн гишүүд Монголын Судар бичгийн хүрээлэнгийн байрны өмнө:
Сууж буй: Зүүн гар талаас Е.В.Козлова (П.К.Козловын эхнэр), Б.Б.Полынов, Н.К.Рерих, Ж.Цэвээн, П.К.Козлов.
Арын эгнээнд: С.А.Глаголев, Г.И.Боровка, Б.М.Куплецкий, В.И.Лисовский, нэр үл мэдэх хүн, Ю.Н.Рерих,
Өдрийн тэмдэглэлд № 13. нег. II 25333, хальс, 13x18 см,
цугл. А1536/478, дард. О.1246/18



Зураг №7. 1926 онд Геохимийн судалгаагаар Туул, Онон голын сав газраар явсан Оросын судлаач К.Л.Островецкийн шинжилгээний ангийн гэрэл зургийн цомог. Цомгийн хавтас, Эрдэнэ Жонон ван Ширнэндамдин гэр бүлийн хамт, Дунд Баянд чулууны дээж авч байгаа байдал. ШУА-ийн Түүх, Угсаатны хүрээлэнгийн түүхийн баримтын сан хөмрөг.

Эдгээрээс өөр, Судар бичгийн хүрээлэнгээс Хэнтий нуруунд ажиллуулсан хэд хэдэн шинжилгээний анги байжээ. Тухайлбал, Б.Я.Владимирцов нарын 1925 оны угсаатан хэл шинжилгээний анги, Куплетскийн 1925 оны геологийн шинжилгээний анги, А.Я.Тугариновын 1928 оны амьтан судлалын шинжилгээний анги, К.Л.Островцкийн 1926 оны геохимийн шинжилгээний анги зэрэг нэлээд олон анги тус бүс нутагт ажилласан мэдээ буй⁵. Б.Я.Владимирцов нар Туул голын эх Бага Хэнтий, Сарьдагийн хавьд очсон боловч хийдийн туурьд хүрээгүй бололтой⁶. Тэд Бурхан Халдун уулын хавь газрыг зорьсон боловч замын бэрхшээлээс шалтгаалан Сарьдаг хавиас урагш буцсан янзтай байна. Харин Борис Михайлович Куплетский нар Судар бичгийн хүрээлэнгээс зөвшөөрөл авч:

“...Богд хан уулын аймгийн Богд хан уулын хошууны нутаг зүүн, баруун Баян, Туул голын эх, Горхи Цагаан булаг, Хуцийн гол, Хан Хэнтий уулын аймгийн Хан Хэнтий уулын хошуу, Баян Улаан хэмээх уулын Цагаан Өндөр уулын хошуудын нутаг Баян Улаан хэмээх уулын зэрэг газруудаар явж чулууны махбод...”⁷ судалсан хэмээн тэмдэглэжээ.

5 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. (1921-1960). I. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. Улаанбаатар. 2011. тал 101-103.

6 Северная Моноглия. II. Предварительные отчеты лингвистической и археологической экспедиций о работах, произведенных в 1925 году. Ленинград. 1927. стр.36-37.


7 МУУТА. Ф-23. Д.1. хн-66.



Зураг №8. Богд хан уулын аймгийн Богд хан уулын хошууны нутаг ажилласан Оросын эрдэмтэн Б.М.Куплетский судалгаа хийсэн тухай баримт. МУУТА. Ф-23. Д.1. ХН-66.




Зураг №9. Туул, Онон голд 1926 онд хээрийн судалгаа явуулсан Судар бичгийн хүрээлэнгийн ажилтан, Оросын судлаач С.А.Кондратьев, эхнэр Мелитина Ивановна нар. С.Чулуун, Т.И.Юсупова. Монголын бурхны шашны соёл. Япон улс. Осака хот. 2012 он.



Түүнээс гадна 1926 онд С.А.Кондратьев болон түүний эхнэр Мелитина Ивановна Кондратьева нар Судар бичгийн хүрээлэнд ажиллаж байхдаа тус байгууллагаас явуулсан Ононгийн шинжилгээний ангийн замдаа Хэнтий уул, Сарьдагийн орчимд зорчсон бололтой байна. М.И.Кондратьева Монголын бурхны шашны сүм хийдүүдийн судалгаа хийсэн бөгөөд тэд тусгайлан тус газарт очсон байх магадлал буй. Гэвч ямар нэгэн тайлан мэдэгдэхгүй байна. Өдрийн тэмдэглэлд ч тусгай мэдээ алга.⁸

8 Жизнь научная деятельность С.А.Кондратьев. (1896-1970). в Монголии и в России. Подготовка к изданию, введение, комментарий и указатели И.В.Кульганек, В.Ю.Жуков. Санкт-Петербург. 2006.



Зураг №10. Туул, Онон голд 1926 онд хэрийн судалгаа явуулсан Судар бичгийн хүрээлэнгийн ажилтан, Оросын судлаач С.А.Кондратьев нарт олгосон үнэмлэх бичгийн эх.

2. Предметы из развалин древнего буддийского монастыря Сардаг~~а~~ и их в верховьях Толы. Экспедиция Ученого Комитета.

Надписи к музейным экспонатам.

1. Керамика и изделия, часть из развалин Кара-каго близ р. Дзэн-гол, ханун дзэн-гольских торговцев. Даты — приблизительно 500 лет. Изготовлено экспедицией Ученого Комитета в 1924 г.
2. Предметы из развалин древнего буддийского монастыря Сардаг~~а~~ и их в верховьях Толы. Экспедиция Ученого Комитета.
3. Сваренная бронзовая чаша. Найдена на р. Узак. Изготовлена Бадмаевым и Аюшевским.
4. Рисунки на скле. Изображения горного козла и знак-ташга, разбившийся из такого изображения. Тюркский период, датирован — 1200 лет. Долина Толы. Изготовлено экспедицией Академии Наук СССР в 1925 году.
5. Предметы из могилы тюркского периода и ограда постройке того же времени. Баин-дабана или близ Найдайху. Даты — 1200 лет. Экспедиция Акад. Наук и Ученого Комитета в 1925 г.

Зураг №11. Улсын музейн сан хөмрөг дэх Сарьдагийн хийдээс В.И.Лисовский нарын цуглуулсан олдворын хүснэгт. МУУТА. Ф-23. Д.1. ХН-156 а.

Харин А.С.Кондратьевийн Хэнтий нуруунд явсан гэрэл зургийн цомог ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнд хадгалагдаж байна. Тэнд Сарьдагийн хийдийн ойролцоох Хагийн Хар нуур, Сарьдагийн уул, Асралт хан, Бэрээвэн хийд, Зааны голын гэрэл зургуудыг авсан байдлыг үзвэл тус хийдийн туурьд зайлшгүй хүрсэн байх магадлалтай. Гэвч хийдийн тухай гэрэл зураг алга. Харин 1926 онд Туулын дээд эхэн чиглэлд явсан К.Л.Островцкийн анги Заан, Тэрэлжийн гол, Гурван баян, Жыдигийн (эдүгээ *Едөг гэж сунжран нэрлэнэ*) даваа, Шороот зэрэг Сарьдагийн хийдийн орчимд явсан гэрэл зургийн цомог ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнд мөн хадгалагдаж байна. Улсын архивын нэгэн мэдээнд тус ангийнхан Сарьдагийн хийдийн орчмоос өнгөт чулуу түүж олсон тухай дурдсаныг үзвэл очсон болов уу гэж таамаглаж байна. Харин ямар нэгэн зураг алга.

Энэ цаг үеэс хойш тус хийдэд тусгайлан очсон шинжилгээний анги мэдэгдэхгүй байна.

Хожим Монголын археологич Х.Пэрлээ 1960-аад онд очсон гэх мэдээлэл байх боловч ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн гар бичмэл, тайлангийн сан хөмрөгт ямар нэгэн бичиж тэмдэглэсэн зүйлс үгүй байна. Харин Монголын Үндэсний музейд Сарьдагийн хийдийн тууриас гарсан цөөн тооны шавар эдлэлүүд байна. Эдгээр эдлэлийг чухам хэдийд музейд шилжүүлсэн тухай тодорхой мэдээлэл алга. Эдгээр нь В.И.Лисовскийн үед ирсэн байж магадгүй. Тухайн үеийн музейн үзмэрийн жагсаалтад тэмдэглэхдээ “предметы из развалин древнего буддийского монастыря Сарьдэк-ин хит в верховьях То́лы. Туул голын эхэн дэх Сарьдагийн хийдийн эвдэрхий сүмийн юмс. Судар бичгийн хүрээлэн...”⁹ хэмээн тэмдэглэсэн бүртгэл буй.

Сарьдагийн хийдийн малтлага судалгаа тэр цагаас хойш бараг тасраад байсан бөгөөд 1995 онд Төв аймгийн Орон нутаг судлах музейгээс санаачлан ШУА-ийн Түүхийн хүрээлэнтэй хамтарч Сарьдагийн хийдэд гүймэг судалгааг дахин явуулжээ. Тус судалгаанд судлаач У.Эрдэнэбат оролцсон бөгөөд тэнд ажилласан тухайгаа товч тайлан бичиж үлдээжээ. Тайланд тэмдэглэснээр тэд үдийн өмнө түр зуур саатахдаа бага зэргийг сорьц малтлага хийсэн байна. Малтлагаар цөөн тооны цац, барилгын эд зүйлс гарсныг авч судалжээ.

XX зууны Монголын шинжлэх ухаанд хамгийн түрүүнд хийгдсэн хайгуул судалгааны гол газар Сарьдагийн хийдийн малтлага судалгаа эхэлсэн шигээ шуурхай байсангүй. Үүний учир нь очих зам саад бэрхшээлтэй, хүн хүч, санхүүгийн нөөц ихээхэн шаардлагатай байв. Нөгөө талаас XVII зууны буюу эзэнт гүрний дараах Чин улсын өмнөх үеийн Монголын бурхны шашны түүхийн чиглэлээр судалгаа хийх хүн бараг байгаагүй зэрэгтэй холбоотой.

9 МУҮТА. Ф-23. Д.1. хн-156 а.



Зураг №12. Судлаачид 2013 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс эхлүүлсэн Сарьдагийн хийдийн малтлагад явж буй байдал. Мориор очих боломжтой.



Зураг №13. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс 2013 онд эхлүүлсэн Сарьдагийн хийдийн малтлагад оролцогчид. Зүүн гар талаас өвөр эгнээнд: Э.Уртнасан, Г.Бямбарагчаа, М.Энхбаатар, Б.Батсүрэн, орон нутгийн газарч, Б.Насанбат. Арын эгнээнд: Б.Санчир, С.Чулуун, С.Өлзийбаяр, Н.Хатанбаатар, Ч.Энхтуул, Б.Сүмбэр, Ж.Энхбаяр

Судалгаанд эргэн ирсэн Сарьдаг хийд

ШУА-ийн Түүхийн хүрээлэн 2011 оноос эхлэн, Монголын эзэнт гүрний дараах үеэс Чин улсын үе хүртэлх түүхийн асуудлыг Монголын түүхийн судалгаанд нарийвчлан оруулах зорилт тавьсан юм. Учир нь сурвалж бичгийн судалгаа бага уг үеийн асуудлыг археологийн болон аман түүхийн хэрэглэгдэхүүнээр нэхэн судлах нь ихээхэн чухал байв. Анх 2013 оны 10 дугаар сард тухайн үед Түүхийн хүрээлэнд ажиллаж байсан хэсэг залуусын оролцсон хээрийн судалгааны баг малтлага судалгааны ажлыг эхлүүлэхээр Төв аймгийн Мөнгөнморьт сумыг зорьсон бөгөөд тус сумын удирдлагаас зөвшөөрөл хүсэн хоёр хоносны эцэст сая бүтэж, уналгын морьдыг орон нутгаас хөлслөн Сарьдагийн хийдэд хүрсэн юм.



Энэ үед 10 дугаар сарын 18 буюу цаг нэлээд оройтсон байсан учир Сарьдаг орчмын уулсаар маш хүйтэрч, бага зэргийн цас ч орсон байв. Уг шинжилгээний ангийн зардлыг хүрээлэнгээс гаргаж байлаа. Хээрийн судалгааны багийг С.Чулуун ахалж, бүрэлдэхүүнд нь доктор С.Өлзийбаяр Б.Батсүрэн, Н.Хатанбаатар, Ч.Энхтуул нарын эрдэм шинжилгээний ажилтнууд оролцсон. Судалгааны багийн нөхцөл байдал туйлын хүнд байсан боловч бид ямартаа ч эхний малтлага судалгааг эхлүүлэх нь зүйтэй гэж үзэж байв.



Зураг №14. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн судлаачид. 2013 он. Хээрийн судалгаа эхлэхэд цас орсон байдал. Сарьдагийн хийд.



Үүнээс гадна тухайн дурсгал буй газрын нөхцөл байдалтай танилцах, дэвсгэр зураглал үйлдэх, бүтэц зохион байгуулалтаа мэдэх, дараа жил нь туурийн хаана нь малтлага судалгаагаа хийхээ төлөвлөх шаардлага гарч байлаа. Тиймээс хамгийн ард байрлах 3-р барилгад сорьц малтлага хийх, гол сүм байсан байх магадлалтай томоохон барилгын баруун хэсэгт хэрмийн дунд мөн малтаж үзэхээр шийдсэн болно. Эхний жилийн малтлага удаан үргэлжилсэнгүй. Учир нь цас орж маш их хүйтэрч ажиллах боломжгүй болсон юм. Гэхдээ ямартаа ч эхний жилийн малтлага дараа жил малтахад юуг анхаарах, хэрхэн очиж болох зэргийг тодорхой мэдүүлж чадсанаараа ач холбогдолтой.





Зураг №15. Сарьдагийн орой дээрээс Бага Хэнтийн нурууны ерөнхий харагдах байдал. Гэрэл зургийг Ч.Энхтуул. 2015 он.





Зураг №16. Сарьдагийн хийдийн голын сүмийн нурангийн цэвэрлэгээ. Гэрэл зургийг Э.Уртнасан. 2014 он.



Зураг №17. Голын сүмийн зүүн жигүүрт хийж буй малтлага судалгаа. Гэрэл зургийг Э.Уртнасан. 2014 он.



Зураг №18. Сарьдагийн хийдийн малтлагын явцад 8 сарын дунд үед цас нэлээд орсон нь малтлагын ажилд сөргөөр нөлөөлж байв. Гэрэл зургийг Э.Уртнасан. 2015 он.

Энэ удаагийн малтлага судалгааны зардал хомс, цаг бэрх, зам саадтай зэрэг олон хүндрэл байсан ч “Чингүнжавын Хар туг сан”-ийн өв соёлдоо сэтгэлтэй залуус Баатарын Сүмбэр, Санчир нар унаа тэрэг, түлш зэргээр дэмжлэг үзүүлсэн юм. Эхний жилийн сорьц малтлага, зураглал үйлдэх ажил ч амжилттай явагдсан билээ.

Түүний дараа 2014 оны 8 дугаар сарын 23-наас 9 дүгээр сарын 23 хүртэлх нэг сар шахам хугацаанд хоёр дахь удаагийнхаа малтлага судалгааг явуулав. Уг ажлын зардал мөн Түүхийн хүрээлэнгээс гарч Үндэсний хэмжээний шинжилгээний ангийг ажиллуулсан. Судлаач Э.Уртнасан талбайн малтлагаа ахалж ажилласан бөгөөд судалгааны багт хүрээлэнгийн голдуу залуус ажиллаж байлаа.

Тэд гол сүмийн зүүн хойд хэсгийн хойморт малтлага хийсэн бөгөөд уг ажил нэлээд хүнд нөхцөлд болсон юм. Учир нь зүүн хойд талын хана нурах аюултай төдийгүй газар нь нэлэнхүйдээ цэвдэг тул маш алгуур явагдаж байлаа. Мөн маш их хэмжээний барилгын нуранги чулуун дараасыг холдуулах ажил байв. Малтлага 9 дүгээр сарын 23-ныг хүртэл үргэлжилсэн бөгөөд нэлээд олон тооны шавар бурхад, голдуу Язгуурын таван бурхан, бурхны шүншиг болох тогоо, тулга, хуяг, дуулга, сэлэм, жижиг шавар бурхад зэрэг зүйлс илэрч олдсон нь уг ажлын гол үр дүн байв.



Зураг №19. Сарьдагийн орой дээрээс баруун тийш Бага Хэнтийн нуруу болон Хагийн хар нуурын алсад харагдах байдал. Гэрэл зургийг Ч.Энхтуул. 2015 он.



Зураг №20. Соёл, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл өөрийн биеэр ирж, Сарьдагийн хийдийн малтлага судалгаатай танилцав. Зураг дээр Э.Уртнасан, Ц.Оюунгэрэл, О.Мэндсайхан. 2014 оны 9 дүгээр сар. Гэрэл зургийг Ч.Энхтуул.

Эдгээрийг малтаж олсны дараа судлаачид Улаанбаатараас Соёлын өвийн төвийнхнийг дуудан, мөн Соёлын сайд асан Ц.Оюунгэрэл нар газар дээр нь ирж малтлага судалгаатай танилцаад зарим дурсгалыг яаралтай авран хамгаалах ажлыг гүйцэтгүүлсэн юм. Хээрийн шинжилгээний анги 9 дүгээр сарын сүүлээр Улаанбаатарт буцаж ирсний дараа Соёлын яамнаас тодорхой дэмжлэг үзүүлэн Соёлын өвийн төвийн мэргэжилтнүүд 10 дугаар сарын 8-наас 18-ны хооронд дахин очиж, бурхад болон бусад зүйлийг Улаанбаатарт татаж авчирчээ. Энэ удаагийн малтлага судалгаа нэлээд үр дүнтэй бөгөөд 10 дугаар сард нийслэл Улаанбаатар хот байгуулагдсаны 375 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний олон улсын хурлыг ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Улаанбаатар хотын захиргаатай хамтран зохион байгуулав.



Зураг №21. Сарьдагийн хийдийн гол сүмийн талбайг цэвэрлэж буй байдал. Гэрэл зургийг Э.Уртнасан. 2014 он.



Энэхүү хурлын үеэр Сарьдагийн хийд буюу Улаанбаатар хотын анхны туурийн тухай илтгэлийг анх удаа хэлэлцүүлэв. Тус хуралд тухайн үеийн хотын дарга Э.Бат-Үүл хүрэлцэн ирсэн бөгөөд уг төслийг хот ивээлдээ авч дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн нь бидний хувьд маш том үйл явдал байсан юм. Ингээд 2015 оны малтлага судалгаанд Улаанбаатар хот 100 гаруй сая төгрөг гаргаж, бидэнд дэмжлэг үзүүлсэн тул судалгааны багийг ихээхэн өргөжүүлэв. Энэ удаад нийт 30 орчим хүнтэй томоохон баг 2015 оны 7 дугаар сарын эхээр Сарьдаг зүг хөдөлсөн юм. Малтлага судалгаа 2015 оны 6 дугаар сарын 21-ээс 9 дүгээр сарын 26 хүртэл нийт 100 гаруй хоног үргэлжлэв. Хээрийн судалгааг С.Чулуун удирдан, талбайн малтлагыг Э.Уртнасан, Ч.Энхтуул нар хариуцан ажиллаж, хүрээлэнгийн ажилтнуудаас гадна өөр залуусыг цалинжуулан ажиллуулсан.

Судалгааны баг нэн түрүүнд маш хүнд асуудал болоод байсан гол сүмийн талбай доторх хожим ургасан хэдэн арван модыг зайлуулах ажлыг гүйцэтгэлээ. Нийт 80 орчим мод, бут сөөг зайлуулах ажлыг бараг 20-оод хоног хийж, талбай үндсэндээ цэвэрхэн болов.



Зураг №22. Сарьдагийн хийдийн гол сүмийн талбайг цэвэрлэж буй байдал. Гэрэл зургийг Э.Уртнасан. 2014 он.

Малтлага судалгааг 2014 онд ажилласан хэсэгт үргэлжлүүлэхийн зэрэгцээ гол сүмийн баруун хэсгийг талбайгаар нь цэвэрлэх ажлыг гүйцэтгэж, барилгын бүтэц, зохион байгуулалтыг мэдэх боломжийг бүрдүүлсэн юм. Уг малтлагаар, барилга бүрэн шатсан төдийгүй ямар зохион байгуулттай байсан нь бараг тодорхой болсон¹⁰.

Мөн зураглалыг шинээр үйлдэж, хамгийн баруун талын хэрэм доторх барилгын жижиг хэсэгт цэвэрлэгээ хийж үзсэн. Судалгааны багийн нөхцөл сайн байсан төдийгүй судлаачид ажилчдын нөөц нэлээд нэмэгдсэн тул хоол хүнсээр хангах, хүрэлцээг буй болгох зайлшгүй шаардлага ихэссэн учир бид нисдэг тэргээр хэрэгцээт зүйлийг хүргэж байв. Учир нь машинаар хоол хүнс тээвэрлэн хүргэх нь нисдэг тэргээр хүргэхээс зардал ихтэй бас цаг алдаж байлаа. Нисдэг тэргийг Батлан хамгаалах яамны Налайхын цэргийн ангиас хөлсөлж байв. Нийт 4 удаа нисдэг тэргээр очсон юм. Мөн тэр үед зарим яам тамгын удирдлага, гадаадын эрдэмтэд хүртэл очиж байдлыг газар дээр нь танилцуулах ажлыг гүйцэтгэж байсан. Нэлээд олон хүн Сарьдагийн хийдийн тухай зөв ойлголттой болсон төдийгүй дараа нь ч бас тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж байв.

10. “XVII зууны Монголын хотууд” төсөл. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн туурьд явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. 2014. С.Чулуун; Э.Уртнасан, Г.Одмагнай; Ч.Энхтуул



Зураг №23. Сарьдагийн хийдийн судлаачдын хүнс, хэрэгслийг нисдэг тэргээр тээвэрлэж буй байдал. Нисгэгч О.Нямбаяр. Гэрэл зургийг Э.Уртнасан. 2015 оны 7 дугаар сар.



Зураг №24. Сарьдагийн хийдийн малтлагад оролцсон судлаачид, ажилчид. Хээрийн судалгааны анги.

Ерөнхийдөө Сарьдагийн малтлага судалгаа нь маш хүнд нөхцөл дэх ажил байв. Хээрийн судалгааны ангийнхан Сарьдагийн малтлага судалгааны ажлын үеэр холбоо харилцаа тасарвал өвдөх, санамсаргүй холдвол төөрөх, баавгай гэх мэт байгалийн зэрлэг амьтанд бариулах, тайгад шатсан түцмэрт өртөх зэрэг маш их аюул эрсдэлийн дунд үргэлж анхаарал болгоомжтой байх шаардлагатай, хүнд нөхцөлд ажиллаж байлаа.

Мөн малтлага судалгаа дээр заавал хамгаалалтын малгай гутал өмсөх, барилгын хана хэрэм нурах аюулаас болгоомжлох гээд асуудал их байсан юм. Бараг орой бүр манайхан G-mobile утсаар мэдээлэл өгч байв. Энэ удаагийн судалгааны ангиас нэлээд ажилчид шантарч бас гэмтэж буцсан. Гэвч анх ажиллаж эхэлсэн Түүхийн хүрээлэнгийн залуус огт шантраагүй бөгөөд ажлаа улам идэвхтэй явуулж, маш их хөдөлмөрлөж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Миний бие энэ хооронд хээрийн судалгааны уг багийг мориор 4 удаа, машинаар 2 удаа, онгоцоор 2 удаа эргэж очсон. Монголын бурхан шашны соёлын томоохон төв болсон Сарьдагийн хийдийн малтлага судалгааны ажилд чин сэтгэлээсээ тусалж, дэмжлэг үзүүлсэн Хан Хэнтийн дархан цаазат газрын захиргаа, түүний дарга Б.Хаш-Маргад, Нийслэлийн удирдлага, Батлан хамгаалах яам зэрэг байгууллагуудад талархах ёстой.

Малтлага судалгаа үндсэндээ голын сүмд явагдсанаас гадна хэрмийн тодорхой хэсэгт зүсэлт хийж үзсэн байна. Энэ нь үндсэндээ хэрмийн зохион байгуулалтыг үзэх гэсэн оролдлого юм. Малтлагын үед Японы Нара хотын сэргээн засварлах хүрээлэнгийн судлаач Шожи өөрийн биеэр очин хэрэм болон барилгын зураглал хийж, 3D нарийн хэмжээст хийхээр тогтсон юм. Малтлагаас гадна байгалийн элдэв нөлөөнөөс хамгаалах, барилгын дотор бүсийг тодорхой байлгах үүднээс байгалийн модыг ашиглан хашаа барьсан юм. Үүнд нэлээд цаг шаардсан бөгөөд хоног алдаж байлаа. Судалгааны баг 9 дүгээр сарын 20-д гартал ажилласан юм.





Зураг №25. Гадаад, дотоодын албаны сурвалжлагч болон сонирхогч олон зочид Сарьдагийн хийдийн малтлага судалгаатай очиж танилцсан болно. 2015 оны 8 дугаар сар. Гэрэл зургийг Ч.Анаргоо.



Зураг №26. Сарьдагийн хийдийн гол талбайд хийж буй малтлагын үеэр. Гэрэл зургийг Ч.Энхтуул. 2015 он.



Зураг №27. Малтлага судалгааны үед байгалийн бэрхшээл маш их хүндрэл үзүүлж байв. Гэрэл зургийг Э.Уртнасан. 2015 он.

Энэ удаагийн судалгаа урт хугацаатай, өргөн бүрэлдэхүүнтэй байсан учир судлаачид маш үр дүнтэй ажиллаж чадсан билээ. Бид олдворуудыг тусгайлан бүртгэж, стандарт уут саванд хийн тээвэрлэхээр бэлтгэж тайлангаа 12 сар гэхэд бэлэн болгож ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн баримт, мэдээллийн төвд шилжүүлж өгөв¹¹.

Харин 2016 оны оны малтлага судалгааг 6 дугаар сарын 20-ноос гаргасан ба энэ удаад Төв аймгийн Цэргийн ангиас хоёр автомашин хөлслөн явав. Гэтэл тухайн жил шавар ус ихтэй байсны улмаас бүтэн 10-аад хоног саатан байж Сарьдагт хүрсэн бөгөөд маш хүнд нөхцөл үүссэн болно. Дахин машин хойноос нь явуулж тухайн цэргийн ангийн машинуудыг татуулж авсан. Энэ удаагийн зардлыг Түүх, Археологийн хүрээлэнгээс санхүүжүүлэв. Санхүүгийн дэмжлэг бага байсан боловч нэг сарын хугацааны зардал олдсон юм. Э.Уртнасан Япон улс руу судалгааны томилолтоор ажиллах болсон учир энэ удаагийн хээрийн судалгааг магистр Ч.Энхтуул хариуцан ажилласан ба судалгааны багийн бүрэлдэхүүнд тус хүрээлэнгийн угсаатны салбар, дундад зууны салбарын голдуу залуус оролцов. Энэ удаагийн малтлага судалгаагаар гол хэрмийн үүдийг нээж үзэх, зүүн талын жижиг чулуун барилгыг малтах зорилго тавьсан юм. Учир нь, гол сүмээс гадна бусад дурсгалт газарт бүтэц зохион байгуулалтыг танин мэдэх, тодорхойлох зорилго байсан учир зүүн талын барилга, үүдэвч, өмнө талын гурван суваргын хамгийн зүүн талынхыг малтан шинжлэх ажлыг хийхээр тогтсон юм.

11. “XVII зууны Монголын хотууд” төсөл. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн туурьд явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. 2015. С.Чулуун; Э.Уртнасан; Ч.Энхтуул; Н.Нандинцэцэг; Б.Батцоож



Зураг №28. Гадаад, дотоодын албаны сурвалжлагч нар болон сонирхогч олон зочид ирж Сарьдагийн хийдийн маллагатай танилцав. 2015 оны 8 дугаар сар. Гэрэл зургийг Ч.Анаргоо.



Малтлага судалгаа нэлээд амжилттай хийгдэж байсан ч нөхцөл байдал маш хүнд байсан учир цаг нэлээд алдсан. Гэвч хэрмийн үүдийг нээж, шатны зохион байгуулалт бидний төсөөлж байснаас огт өөр байсныг тодруулсан юм. Өөрөөр хэлбэл, бид үүднээс шууд буусан шаттай гэж тооцоолж байсан боловч малтлагаар үүднээс хоёр тал руугаа буусан шаттай байсныг тодруулсан болно. Үүдний байдал, хаалганы зохион байгуулалт зэргийг гэрчлэх (хаалганы бариул гэх мэт) эд өлгийн зүйлс гарсан.

Харин зүүн талын сүмийн малтлага хийхэд нэлээд хүндрэлтэй бөгөөд цэвдэг ихтэй тул ажил алгуур явагдаж байв. Малтлагын үр дүнд сүмийн модон хаалга илэрсэн бөгөөд цэвдгээс шалтгаалан энэ удаад онгойлгож чадаагүй орхисон юм. Ийнхүү 7 дугаар сарын эцэс хүртэл ажиллаад энэ удаагийн судалгааны анги буув. Мэдээж санхүүжилтээс ихээхэн зүйл шалтгаалсан болно. Уг малтлагаас модон барилгын холбоотой зүйлс нэлээд илэрсэн нь бусад барилгыг бодвол олон шинэ зүйлийг тодорхойлох боломжийг бидэнд олгосон. Энэ удаагийн малтлагад бид сэргээн засварлагчийг авч ажиллуулж, шууд газар дээр нь тодорхой боломжтой зүйлсийг сэргээн засварлах, бэхжүүлэх, тодорхойлолт бичих ажлыг хийлгэж байсан нь бас өмнөх жилүүдийн судалгаанаас нэлээд өвөрмөц үр дүн сайтай байсан¹².

Хамгийн сүүлийн жилийн малтлага буюу 2017 оны хээрийн судалгааны ажил эхлэхээс өмнө бид Улаанбаатар хотын захиргаанд дахин санал тавьснаар тодорхой хэмжээний санхүүжилтыг тухайн үеийн хотын дарга Су.Батболд олгохоор шийдвэрлэсэн тул арай өргөн бүрэлдэхүүнтэй баг бүрдүүлэн гарав. Бид мөн Төв аймгийн Цэргийн ангиас машин түрээслэн явсан бөгөөд өмнөх жилд нэлээд алдаа гарсан учир энэ удаад хаана хаанаа ихээхэн бэлтгэл сайтай байхыг хичээж ажилласан нь Сарьдагт маш шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн юм. Ер нь Сарьдагт хүрэх, Сарьдагаас буух хоёр хамгийн хүнд асуудал байв. Учир нь, тодорхой сайн унаа олдохгүй, олдсон ч үнэ ихтэй байх жишээтэй. Гэвч цэргийн ангийн удирдлага маш найрсаг хүлээн авч, бүхий л боломжоороо тусалсан билээ.

Бид энэ удаагийн малтлагаараа өнгөрсөн жилийн дутуу орхисон зүүн талын модон сүмийг малтах, өмнө дутуу орхисон гурван суваргын хамгийн зүүн талынхыг малтах зорилго тавин ажилласан. Малтлагын явцад модон сүмийн чимэглэл бүхий мод, мөн өмнө гарч байсан язгуурын бурхад зэрэг эд өлгийн зүйлс илэрч олдсон. Мөн сүмийн оройн төмөр хонх илэрч гарав. Эндээс илэрч олдсон язгуурын бурхдын нэг онцлог нь шаврын гадуур алтадмал түрхэцтэй байсан нь нэлээд хүндэтгэлийн маягтай байсан болов уу гэсэн таамаг дэвшүүлэхэд хүргэсэн юм. Малтлага үндсэндээ 20 гаруй хоног үргэлжилсэн ба нэлээд үр дүнтэй болсон билээ¹³.

12 “XVII зууны Монголын хотууд” төсөл. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн туурьд явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. 2016. С.Чулуун; Ч.Энхтуул; Н.Нандинцэцэг.

13 “XVII зууны Монголын хотууд” төсөл. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн туурьд явуулсан археологийн малтлага судалгааны ажлын тайлан. 2017. С.Чулуун; Ч.Энхтуул.

Харин энэ удаагийн малтлагаар барилгын бүтэц зохион байгуулалт, малтлага судалгааны дутуу орхигдсон хэсэг зэргийг бүгдийг хянаж үзэж дууссан бөгөөд ажлаа үндсэндээ зогсоох шийдэлд хүрэв. Учир нь, энэ таван жилийн хугацаанд тодорхой судалгааг явуулж Сарьдагийн хийдэд томоохон малтлага судалгаа хийсний үр дүнд XVII зууны Өндөр гэгээн Занабазарт холбогдох Рибогижай Ганданшадавлин хийд буюу Номын Их Хүрээ мөн болохыг хөдөлшгүй нотлох баримт илэрч олдсон бөгөөд цаашид тодорхой хугацааны дараа тогтвортой санхүүжилт олж, урт хугацаагаар малтан судлах шаардлагатай гэсэн үүднээс малтлагыг түр зогсоосон болно.

Бид олдсон олдворуудыг нэг бүрчлэн бүртгэж, тодорхой хэсгийг нь сэргээн засварлаж, он цаг тогтоох ажлыг гадаадын лабораториудад явуулж хийлгэх, судалгааны ажилд оролцсон залуусыг дахин сургах, дадлага хийлгэх, мэргэшүүлэх ажлыг гүйцэтгэж байгаа болно.

Сарьдагийн хийдийн судалгаа нь XVII зууны Монголын бурхны шашны хөгжил, хот байгуулалт, сүм хийдийн барилгын онцлог, тухайн үеийн гадаад харилцааны үйл ажиллагаа, монголчуудын гар урлал, урлагийн хөгжил зэргийг тодорхойлоход чухал малтлага байсан төдийгүй Өндөр гэгээн Занабазарын уран бүтээлийн нэг гол ордон байсныг шууд гэрчилж байгаа юм. Нөгөө талаар бичгийн болон аман түүхийн судалгааны эх сурвалж баримтыг шууд нөхөж байгаа болон бодит эд өлгийн зүйлсээр нотолж байгаагаараа онцлогтой. Тиймээс бид судалгааны ажлын үйл явц, түүний нөхцөл байдал, гарч буй үр дүнг илэрхийлсэн энэхүү бүтээлийг туурвиж байгаа юм.





Зураг №29. Сарьдагийн хийдийн малтлага хийхээр мориор явж буй шинжилгээний ангийн зураг. 2015 он. Гэрэл зургийг Э.Уртнасан.